



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/109

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт  
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 2 иргэний гаргасан хүсэлтийн дагуу 0.1100 га (0.1100м<sup>2</sup>) газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын .....-ны өдрийн  
А/1.0.7 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ  
ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Иргэндийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Дэлгэрхаан овгийн Эрдэнэбат Аззаяа /РЮ82052606/	6712017215	13-р баг 45а-3 тоот	Аймгийн Засаг даргын 2012.11.23-ны өдрийн А/330 дугаар захирамжийн хавсралтын 8 дахь заалтын 5 дахь баганын "500м <sup>2</sup> " гэснийг "580м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /кадастрын мэдээллийн санд зөрүүтэй орсон/
2	Хөх нохой овгийн Чулуун Батболд /РХ73061013/	6712008314	8-р баг 9-63 тоот	Сумын Засаг даргын 2006.08.03-ны өдрийн №90 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 5 дахь заалтын 3 дахь баганын "500м <sup>2</sup> " гэснийг "520м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /кадастрын мэдээллийн санд зөрүүтэй орсон/

Нийт талбайн хэмжээ-1100м<sup>2</sup>

-----oOo-----